



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 06 сарын 16 өдөр

Дугаар А/430

Булган сум

**Аймгийн зочлох үйлчилгээний
салбарын бизнес эрхлэгчдэд сургалт
зохион байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Аялал жуулчлалын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.7 дахь заалт, 23 дугаар зүйлийн 23.1.1, 23.1.8, 23.1.9 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны “Булган аймгийн 2026 оны төсөв батлах тухай” XII/90 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2026 оны “Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардлыг шинэчлэн батлах тухай” А/97 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бүгд Найрамдах Солонгос Улсын “КОЙКА” олон улсын хамтын ажиллагааны байгууллагатай хамтран аялал жуулчлалын асуудлаар хэлэлцүүлэг өрнүүлэх тул аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй зочлох үйлчилгээний салбарын бизнес эрхлэгчдийг идэвхтэй оролцуулан “Зочлох үйлчилгээний менежмент”, “Дижитал маркетинг”-н сургалтуудыг, үр дүнтэй зохион байгуулсугай.

2.Сургалтыг аймгийн хэмжээнд үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын дарга (Г.Алдармөнх)-д үүрэг болгосугай.

3.Сургалт зохион байгуулахад шаардагдах төсвийг хавсралтаар баталж, 1,710,000 (нэг сая долоон зуун арван мянга) төгрөгийг Аялал жуулчлалыг хөгжүүлэх жилийн ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

06
А.Н.50
Аймгийн Засаг даргын 2026 оны
дугаар сарын 15-ны/ний өдрийн
дугаар захирамжийн хавсралт

СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХАД ШААРДАГДАХ ТӨСӨВ

д/д	Зардлын төрөл	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөгөөр)	Нийт үнэ (төгрөгөөр)
1	2	3	4	5
1	Сургалтад оролцогчдын цайны завсарлагааны зардал	100	7,500	750,000
2	Сургагч багш нарын хоолны зардал	5	50,000	250,000
3	Анонс (хулдаасан хэвлэл)	1	548,000	548,000
4	Цэвэр ус (12ш)	9	18,000	162,000
				1,710,000

--o0o--